



ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 17/39

Чингис хот


Хэсгийн ахлагч, олон нийтийн байцаагч
нартай гэрээ байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 02 дугаар тогтоол, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.3.5 дахь заалтыг ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ажиллаж буй Хэсгийн ахлагч нарын сарын урамшуулал 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Тамгын газрын нягтлан бодогч (Д.Баярцэцэг)-д зөвшөөрсүгэй.

2.Хэсгийн ахлагч нартай гэрээ байгуулан, гэрээг дүгнэж үүрэгжүүлэн ажиллахыг Тамгын газрын дарга (Г.Лхагвабаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР